

ХӨВСГӨЛ АЙМГИЙН АРБУЛАГ СУМЫН  
ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВ

**АРБУЛАГ СУМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ХООЛ ХҮНС НИЙЛҮҮЛЭХ ГҮЙЦЭТГЭГЧ  
СОНГОХ ТЕНДЕРИЙН БАРИМТ БИЧИГ**

Дугаар: ХӨААБСЭМТ/20240202004

## Нэг. ҮНИЙН САНАЛ АВАХ УРИЛГА

2024.05.17

**Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Эрүүл мэндийн төв нь хоол хүнс нийлүүлэх гүйцэтгэх тухай үнийн санал ирүүлж тендерт оролцохыг ”Тэвхэн”ХХК, “Сүлд бумбат“ ХХК, “Бэст Мөрөн”ХХК компанийг урьж байна.**

Үнийн санал ирүүлэх ажлын зураг, техникийн тодорхойлолт болон холбогдох бусад материалыг хавсаргасан болно.

Үнийн саналыг **2024 оны 05 сарын 24-ны өдрийн 12 цаг 00 минут**-аас өмнө **Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ**, утас **80010713**, хаягаар ирүүлнэ. Тендерийг цахим хэлбэрээр зохион байгуулж байгаа тул үнийн саналыг [www.tender.gov.mn](http://www.tender.gov.mn) цахим хаягаар ирүүлнэ.

Үнийн саналыг нээлтэд оролцох хүсэлтэй тендерт оролцогчдыг байлцуулан **2024 оны 05 сарын 24**-ны өдрийн **12 цаг 30 минут<sup>1</sup>**-т нээнэ.

Дотоодын давуу эрх тооцох эсэх: **Тооцно**

Сонирхсон этгээд тендерийн баримт бичиг болон бусад мэдээллийг доорх хаягаар авч болно.

**Хөвсгөл аймаг, Арбулаг сум, 5-р баг,  
ЗДТГазар ,  
утас: 95382428**

<sup>1</sup> Тендерийг хүлээж авах эцсийн хугацааг дууссанаас хойш 1 цагийн дотор байна.

## Хоёр. ТЕНДЕРТ ОРОЛЦОГЧДОД ӨГӨХ ЗААВАРЧИЛГАА

- 1. Эрх бүхий тендерт оролцогч ба эрх бүхий бараа**
  - 1.1. Тендерт оролцогч нь “Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай” хуулийн 14-16 дугаар зүйл буюу Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт /цаашид “ТШӨХ” гэх/-д заасан холбогдох шаардлагыг хангасан байна.
- 2. Тендер ирүүлэх, тендерийн нээлт**
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.1. Захиалагч тендерүүдийг ТШӨХ-д заасан захиалагчийн хаягаар, ТШӨХ-д заасан огноо, цагаас өмнө хүлээн авна.
  - 2.2. Тендерийг ТШӨХ-д заасан хугацаанд, ТШӨХ-д заасан газар нээлтийг хийнэ.
- 3. Тендерийн иж бүрдэл**
  - 3.1. Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:  
Тендерт оролцогчийн бэлтгэж ирүүлэх тендер нь дараах зүйлээс бүрдэнэ. Үүнд:
    - (а) Үнийн санал;
    - (б) Үнийн болон нийлүүлэлтийн хуваарь;
    - (в) Чадварын мэдээлэл /санхүүгийн тайлан, туршлагын мэдээлэл, гэрээ гүйцэтгэсэн ажлын гэрээний хуулбар/ болон бусад баримт бичиг;
    - (г) Шаардлагатай тусгай зөвшөөрөл;
- 4. Тогтмол үнэ**
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
  - 4.1. Тендерт оролцогчийн санал болгосон үнэ нь төгрөгөөр илэрхийлэгдсэн байх ба гэрээг хэрэгжүүлэх хугацаанд тогтмол байна. Үнийн тохируулгын нөхцөлтэйгээр ирсэн үнийн саналаас татгалзана.
- 5. Техникийн тодорхойлолт ба арилжааны нөхцөлүүд**
  - 5.1. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг тендерт оролцогч батлах үүрэгтэй. Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагаас зөрсөн тохиолдолд тухайн тендерээс татгалзана.
  - 5.2. Тендерт оролцогч нь энэ баримт бичигт заасан арилжааны нөхцөлүүдийг бүрэн хангасныг албан бичгээр батлан тендерийн хамт ирүүлнэ.

- 6. Үнийн саналын хүчинтэй байх хугацаа**
- 6.1. Үнийн санал нь түүнийг ирүүлсэн өдрөөс хойш **45** хоногийн хугацаанд хүчинтэй байна.
- 7. Санал болгосон үнэ, түүнийг үнэлэх**
- 7.1. Тендерт оролцогч үнийн саналдаа холбогдох бүх даатгал, тээврийн зардал, татвар, хураамжийг оруулж үнийн хуваарийн дагуу ирүүлнэ.
- 7.2. Бараа нийлүүлэлтийн хуваарыт заасан бараа нь **TШӨХ-д** заасан багцаас бүрдэх ба багцад орсон нэр төрөл бүрд заавал үнийн санал ирүүлнэ.
- 7.3. Захиалагч техникийн тодорхойлолт болон бусад нөхцөл шаардлагыг хангасан оролцогчдын үнийг харьцуулж хамгийн бага үнэ санал болгосон тендерт оролцогчид гэрээ байгуулах эрхийг олгоно.
- 8. Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл**
- 8.1. Захиалагч нь шалгарсан тендерт оролцогчид гэрээ байгуулах эрх олгосныг түүний тендер хүчинтэй байх хугацаа дуусахаас өмнө албан бичгээр мэдэгдэнэ. Энэ мэдэгдэлд гэрээнд заасны дагуу хийгдэх ажилд төлөх мөнгөн дүн буюу гэрээний үнийг заана. Гэрээний үнэ нь залруулга болон үнийн хөнгөлөлтийг (түүний дотор нөхцөлтэй үнийн хөнгөлөлт) тооцсон тендерийн үнэ байна.

## Гурав. ТЕНДЕР ШАЛГАРУУЛАЛТЫН ӨГӨГДЛИЙН ХҮСНЭГТ

Худалдан авах барааны талаарх дор дурдсан өгөгдлүүд нь тендерт оролцогчид өгөх зааварчилгаа/ТОӨЗ/-ны холбогдох зүйл, заалтын мэдээллийг гүйцээх, нэмэлт оруулах, эсхүл өөрчлөх зорилготой. Хэрэв ТОӨЗ-ны зүйл, заалттай зөрчилдвэл энэхүү хүснэгт дэх мэдээллийг зөв гэж үзнэ.

<b>ТОӨЗ-ны холбогдох заалт</b>	<b>А. Ерөнхий зүйл</b>
<b>ТОӨЗ 1.1(а)</b>	Захиалагч нь: <b>Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЭМТөв</b>
<b>ТОӨЗ 1.1(б)</b>	Тендер шалгаруулалтын нэр болон ялгагдах дугаар: <b>Хөвсгөл аймгийн ЭМТөвд Хоол хүнсний лүүлэх</b> <b>ХӨААБСЭМТ/20240202004</b>
<b>ТОӨЗ 1.1(в)</b>	Энэхүү тендер шалгаруулалт нь дараах нэр, дугаар бүхий багцуудаас бүрдэнэ: <b>багцгүй</b>
<b>ТОӨЗ 1.1(г)</b>	Санхүүжилтийн эх үүсвэр нь: <b>Улсын төсвийн ургал зардал,</b> <b>Батлагдсан төсөв нийт 47,645,600 төгрөг.</b>
<b>ТОӨЗ 1.1(д)</b>	Тендерт оролцогч нь ТОӨЗ-ийн 4.2.1-4.2.9-д дурьдсан нөхцөл үүссэн эсэх тухай мэдэгдлийг захиалагчид бичгээр гаргаж, эдгээр нөхцөл үүссэн эсэхийг магадлах зорилгоор захиалагчаас тавьсан шаардлагын дагуу холбогдох баримт, нотолгоог тендерт хавсарган захиалагчид ирүүлнэ.
	<b>Б. Тендерийн баримт бичиг</b>
<b>ТОӨЗ 1.1(е)</b>	Тендерт оролцогч тендерийн баримт, бичиг дэх бүх зааварчилгаа, нөхцөл, маягт болон техникийн тодорхойлолтыг нягталж үзэх шаардлагатай бөгөөд тендерийн баримт бичигт шаардсан мэдээлэл, баримт материалыг ирүүлээгүй байх, маягтыг дутуу бөглөж ирүүлэх нь тухайн тендерээс татгалзах үндэслэл болно.
<b>ТОӨЗ 1.1(ё)</b>	Захиалагчаас тендерийн баримт бичигтэй холбоотой тодруулга авах хаяг: Тодоруулгыг <a href="http://www.tender.gov.mn">http://www.tender.gov.mn</a> сайтаар дамжуулан оролцогчид өгнө.
<b>ТОӨЗ 1.1(ж)</b>	Тендерийн баримт бичгийн талаар тодруулга авах хүсэлтийг хүлээн авах хугацааны хязгаар тендер хүлээн авах эцсийн хугацаанаас ажлын <b>5 хоногоос багагүй байна.</b>
	<b>В. Тендер бэлтгэх</b>
<b>ТОӨЗ 3.1(а)</b>	Тендерийн хэл нь <b>Монгол хэл</b> байна.
<b>ТОӨЗ 3.1(б)</b>	Тендерт оролцогч нь тендерийн баримт бичгийг дор дурьдсан хэсэг, бүлэгт заасан дараалалд нийцсэн иж бүрдэл баримт бичиг болгон бэлтгэх буюу шаардлагатай бол ТОӨЗ-д заасны дагуу хийсэн нэмэлт өөрчлөлтийг тусгасан байна. Үүнд:
	<b>I. ХЭСЭГ</b>
	Бүлэг 1. Тендерт оролцогчдод өгөх зааварчилгааны дагуу бэлтгэсэн баримт бичиг, нотлох баримт Бүлэг 2. Тендер шалгаруулалтын өгөгдлийн хүснэгт, түүнд заасан баримт бичиг, нотлох баримт Бүлэг 3. Тендерийн үнэлгээнд харгалзах шалгуурт хамаарах дараах баримт бичгийг ирүүлэх. Үүнд:

	<p>-ТОӨЗ-ны 3.1-д заасан нэмэлт материал,</p> <p>-тендерт оролцогчийг тухайн тендерт оролцох эрх бүхий гэдгийг тогтооход шаардлагатай нотлох баримт</p> <p>-Тендерт оролцогчийг төлөөлж тендерт гарын үсэг зурах этгээдийн гарын үсгийг баталгаажуулж гаргасан итгэмжлэл</p> <p>-тендерт оролцогчийг тухайн гэрээг хэрэгжүүлэх чадвартай болохыг тогтооход шаардлагатай нотлох баримтууд</p>															
	II. ХЭСЭГ															
	<p>Бүлэг 4. Гэрээний ерөнхий, тусгай нөхцөлийг зөвшөөрөх эсэх санал, шийдвэрийг ирүүлэх</p>															
	III. ХЭСЭГ															
	<p>Бүлэг 6. Гэрээний ерөнхий, тусгай нөхцөлийг зөвшөөрөх эсэх санал, шийдвэрийг багц тус бүрд ирүүлэх</p> <p>Бүлэг 7. Гүйцэтгэлийн баталгаа шаардсан тохиолдолд ирүүлэх эсэх саналыг саналыг багц тус бүрд ирүүлэх /уг тендерт шаардлагагүй/</p> <p>Бүлэг 8. Урьдчилгаа төлбөрийн баталгаагаар санхүүжилт авах эсэх талаарх санал /уг тендерт шаардлагагүй/</p>															
ТОӨЗ 3.1 (в)	<p>Тендерт оролцогч дараах нэмэлт материалыг өөрийн тендерт хавсралтаар ирүүлнэ. Үнд: Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 14-16 дугаар зүйл буюу тендерт оролцогч гэрээ хэрэгжүүлэх чадвартайгаа нотолж тендерт ирүүлэх чадварын мэдээллүүд: Үнд:</p> <p>1. Сүүлийн 1 жил буюу 2023 онд санал болгосон үнийн дүнгийн 100 хувиас дээш хэмжээний борлуулалтын орлоготой байсныг нотлох баримт бичиг /санхүүгийн тайлан, аудитын дүгнэлт/ ирүүлнэ.</p> <p>2. Сүүлийн 1 жил 2023 онд шатахуун нийлүүлэх ажлыг гэрээгээр гүйцэтгэж байсан туршлагатай байх.</p> <p>3. Татвар, нийгмийн даатгал, шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагуудын тодорхойлолтууд ирүүлнэ. Тодорхойлолтууд нь гаргаснаас хойш 1 сарын дотор хүчинтэй байна. Татвар, хураамж, төлбөрөө төлсөн эсэхийг тендер нээсэн өдрөөр тооцно. Татвар, нийгмийн даатгал бусад байгууллагад хугацаа хэтэрсэн өр төлбөртэй, сүүлийн 3 жилд ял шийтгэлтэй, одоо өр төлбөртэй байсан нь холбогдох байгууллагуудаас ирүүлсэн тодорхойлолтоор нотлогдсон тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>4. Тендерт оролцогч олон багцтай тендерт оролцох болон хэрэгжүүлж байгаа буюу хэрэгжүүлэх эрх авсан гэрээний талаарх мэдээлэл, тус гэрээнд ажиллаж байгаа, ажиллуулах голлох ажилчид, багаж хэрэгсэл, агуулахыг танилцуулах бөгөөд тэдгээр нь санал болгож буй тендерийн саналтай давхардсан тохиолдолд болон уг мэдээлийг ирүүлээгүй эсвэл худал мэдүүлсэн нөхцөлд оролцогчийн ирүүлсэн тендерээс татгалзах үндэслэл болно. Хэрэгжүүлж байгаа болон хэрэгжүүлэх эрх авсан гэрээний хугацаа, өртөг, захиалагчийн албан ёсны хаяг, байршил, харилцах утасны дугаарын талаарх мэдээллийг ирүүлнэ.</p> <p>5. Тендерт оролцогчийн санал болгосон нийт ажилтан, ажилчид нь өөрийн компанийн үндсэн ажилтан байх ба тэдгээр ажилтнуудын НДШ-ийг тендерт оролцогч өөрөө төлсөн болохыг НД-ын байгууллагын НД№7, НД№8 маягтаар гаргасан тодорхойлолт лавлагaa, ажилтны нийгмийн даатгалын дэвтэрийн наториатоор батлуулсан хуулбарыг тус тус үндэслэн тогтооно.</p>															
	<table border="1"> <tr> <td>Албан тушаал</td> <td>Мэргэжил, боловсрол</td> <td>Хүний тоо</td> <td>Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо</td> <td>НД-ийн дэвтрийн дугаар</td> </tr> <tr> <td>Менежер</td> <td>Худалдаанын мэргэжилтэн</td> <td>1</td> <td>2-оос жил</td> <td></td> </tr> <tr> <td>Жолооч</td> <td>Жолооч</td> <td>1</td> <td>2-оос</td> <td></td> </tr> </table>	Албан тушаал	Мэргэжил, боловсрол	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо	НД-ийн дэвтрийн дугаар	Менежер	Худалдаанын мэргэжилтэн	1	2-оос жил		Жолооч	Жолооч	1	2-оос	
Албан тушаал	Мэргэжил, боловсрол	Хүний тоо	Мэргэжлээрээ ажилласан жилийн тоо	НД-ийн дэвтрийн дугаар												
Менежер	Худалдаанын мэргэжилтэн	1	2-оос жил													
Жолооч	Жолооч	1	2-оос													

	<p>6. Улсын бүртгэлийн гэрчилгээний эх хувиас татсан хуулбарыг нотариатаар батлуулж ирүүлнэ.</p> <p>7. хоол хүнсний чиглэлээр худалдах, борлуулах тусгай зөвшөөрлийн гэрчилгээний хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ.</p> <p>8. Тендерт оролцогч Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль болон бусад хууль тогтоомжийг зөрчсөн нөхцөл бүхий тендер ирүүлсэн оролцогчийн тендерээс татгалзана</p> <p>9. Мэргэжлийн хяналтын газар, Онцгой байдлын газраас гаргасан ажлын байрны дүгнэлтийн хуулбар</p> <p>10. Санал болгож буй барааны нийлүүлэлтийн хуваарийг боловсруулж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж тендерт ирүүлнэ. Ирүүлээгүй тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p> <p>11. Санал болгож буй санхүүжилтийн хуваарийг боловсруулж тендерт оролцогчийн эрх бүхий албан тушаалтнаар баталгаажуулж тендерт ирүүлнэ.</p> <p>12. Захиалагчид шаардлагатай тохиолдолд зээлээр хоол хүнс нийлүүлэхийг зөвшөөрсөн тухай албан бичгийг ирүүлнэ.</p> <p>Дээрхи нэмэлт материалыудаас нэг буюу хэд хэдэн баримт бичиг нотлох баримт ирүүлээгүй, эсвэл шаардлага хангахааргүй, баталгаажилтгүй ба зөрчил бүхий хуурамч нотлох баримтууд ирүүлсэн, сүүлийн 3 жилд нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээний чанар хангалтгүй байсан нь өмнөх захиалагч байгууллагуудын тодорхойлолтоор болон хяналт шалгалтын байгууллагын дүгнэлтээр нотлогдсон зэрэг тохиолдолд тендерээс татгалзах үндэслэл болно.</p>
<b>ТОӨЗ 3.1(г)</b>	Хувилбарт тендер ирүүлэхийг “зөвшөөрөхгүй”
<b>ТОӨЗ 3.1(д)</b>	Олон улсын худалдааны Incoterms/Инкотермс -ийн хувилбар: “ <i>Incoterms 2000</i>
<b>ТОӨЗ 3.1(е)</b>	Бараа хүргэгдэх газар: <i>Хөөсгөл аймгийн Арбулаг сумын Эрүүл мэндийн төв</i> .
<b>ТОӨЗ 3.1(ё)</b>	“Бараа хүргэгдэх эцсийн цэг (Захиалагчийн агуулах, эсхүл барааг эцсийн хэрэглэгчид хүргэх байршил)”: <i>Хөөсгөл аймгийн Арбулаг сум 5-р баг ЗДТГ</i>
<b>ТОӨЗ 3.1(ж)</b>	Тендерт оролцогчийн санал болгосон үнийг гэрээний хэрэгжилтийн явцад “ <i>тохиуулахгүй</i> ” Гэрээний үнэ тогтолц
<b>ТОӨЗ 3.1(з)</b>	Тендерийн валют: <i>Төгрөг байна</i> .
<b>ТОӨЗ 3.1(и)</b>	Үйлдвэрлэгч, борлуулагчийн зөвшөөрөл: “ <i>шаардлагатай</i> ” <i>Үйлдвэрлэгч, нийлүүлэгчийн зөвшөөрөл, мэргэжлийн байгууллагын дүгнэлтийг тус тус ирүүлнэ.</i>
<b>ТОӨЗ 3.1(й)</b>	Санхүүгийн тайлан ирүүлэх жилийн тоо: <i>2023 оны санхүүгийн тайланг аудитын дүгнэлтийн хамт ирүүлэх бөгөөд тайлан ирүүлсэн жилд ашигтай ажилласан байна</i> .

<b>ТОӨЗ 3.1 (к)</b>	<p>Ижил төстэй ажил гэрээгээр гүйцэтгэсэн туршлагын мэдээлэл ирүүлэх жилийн тоо: 1 жил /2023/</p> <p><b>Сүүлийн 1 жилд төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжид тээвэр шатахуун нийлүүлж байсан гэрээ, гэрээний хэрэгжилтийн мэдээллийг дараах хүснэгтээр ирүүлнэ:</b></p> <table border="1"> <thead> <tr> <th rowspan="2">№</th><th rowspan="2">Гэрээний нэр</th><th rowspan="2">Барааны нэр</th><th rowspan="2">Гэрээний үнэ /мян.төг/</th><th colspan="3">Захиалагчийн мэдээлэл</th></tr> <tr> <th>Нэр</th><th>Хаяг</th><th>Утасны дугаар</th></tr> </thead> <tbody> <tr> <td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td><td></td></tr> </tbody> </table> <p>Дээрх мэдээллийн хамт өмнөх захиалагч байгууллагуудтай сүүлийн 1 жилд байгуулсан гэрээний хуулбар, гэрээ дүгнэсэн акт, гэрээний хэрэгжилтийн үр дүнгийн талаар өмнөх бүх захиалагчийн тодорхойлолтыг ирүүлнэ.</p>	№	Гэрээний нэр	Барааны нэр	Гэрээний үнэ /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл			Нэр	Хаяг	Утасны дугаар							
№	Гэрээний нэр					Барааны нэр	Гэрээний үнэ /мян.төг/	Захиалагчийн мэдээлэл										
		Нэр	Хаяг	Утасны дугаар														
<b>ТОӨЗ 3.1(л)</b>	<p>Барааг нийлүүлсний дараах засвар, үйлчилгээ: <i>Чанаргүй бараа нийлүүлсэн тохиолдолд шинэ бараагаар солих, захиалагчид учирсан хохиролыг нөхөн төлнө. Нийлүүлсэнээс хойшихи хадгалалт, хамгаалалтаас шалтгаалсан аливаа чанар аюулгүй байдалтай холбоотой асуудлыг захиалагч хариуцна.</i></p>																	
<b>ТОӨЗ 3.1(м)</b>	<p>Борлуулалтын хэмжээ: 2023 онд төрийн байгууллага, төрийн болон орон нутгийн өмчийн аж ахуйн нэгжид гэрээгээр хоол хүнс нийлүүлж байсан туршлагатай байна.</p>																	
<b>ТОӨЗ 3.1(н)</b>	<p>Гүйцэтгэгчээр ажилласан байх жилийн тоо: <i>2023 он</i></p>																	
<b>ТОӨЗ 3.1(о)</b>	<p>Гэрээг гүйцэтгэхэд зайлшгүй шаардлагатай үндсэн тоног төхөөрөмжийн жагсаалт: <i>багаж хэрэгслийн үзүүлэлт, жагсаалтыг доорх хүснэгтэд зааснаар бэлтгэж, тэдгээрийн гэрчилгээний эхээс татсан хуулбарыг нотариатаар баталгаажуулж ирүүлнэ /машин тоног төхөөрөмж, багаж хэрэгсэл нь компанийн өөрийн эзэмшилийнх эсхүл түрээсийнх байж болох бөгөөд 2023 оны түрээсийн гэрээний эх хувьийг ирүүлнэ/ Үүнд:</i></p> <table border="1" data-bbox="473 1154 1464 1401"> <tbody> <tr> <td data-bbox="473 1154 790 1311"><i>Машин тоног, төхөөрөмж, техник хэрэгслийн нэр, зориулалт</i></td><td data-bbox="790 1154 927 1311"><i>Тоо ширхэг</i></td><td data-bbox="927 1154 1108 1311"><i>Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар</i></td><td data-bbox="1108 1154 1181 1311"><i>Эзэмшигч</i></td><td data-bbox="1181 1154 1464 1311"><i>Чанар байдал ашиглалтад орсон огноо</i></td></tr> <tr> <td data-bbox="473 1311 790 1401"><i>Хүнсний бүтээгдхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл</i></td><td data-bbox="790 1311 927 1401"></td><td data-bbox="927 1311 1108 1401"></td><td data-bbox="1108 1311 1181 1401"></td><td data-bbox="1181 1311 1464 1401"></td></tr> </tbody> </table>					<i>Машин тоног, төхөөрөмж, техник хэрэгслийн нэр, зориулалт</i>	<i>Тоо ширхэг</i>	<i>Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар</i>	<i>Эзэмшигч</i>	<i>Чанар байдал ашиглалтад орсон огноо</i>	<i>Хүнсний бүтээгдхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл</i>							
<i>Машин тоног, төхөөрөмж, техник хэрэгслийн нэр, зориулалт</i>	<i>Тоо ширхэг</i>	<i>Улсын бүртгэлийн дугаар, гэрчилгээний дугаар</i>	<i>Эзэмшигч</i>	<i>Чанар байдал ашиглалтад орсон огноо</i>														
<i>Хүнсний бүтээгдхүүн тээвэрлэх зориулалтын тээврийн хэрэгсэл</i>																		
<b>ТОӨЗ 3.1(ө)</b>	<p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн хэмжээ: Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүн: <i>Төсөөт ортгийн 30%-иас багагүй байх</i></p> <p>Түргэн хөрвөх чадвартай хөрөнгө болон авах боломжтой зээлийн нийт дүнг дараах шалгуур үзүүлэлтүүдийг аль нэгээр эсвэл тэдгээрийн нийлбэрээр нь тодорхойлно.</p> <p><i>-Байгууллагын харилцах банкин дахь дансны үлдэгдэл /банкны тодорхойлолт, дансны хуулгаар тодорхойлно./ Арилжааны банкнаас зээл олгох бололцоотой болохыг нотлох тодорхойлолт /Жич: аль нэгээр нотолсон баримт./</i></p>																	
<b>ТОӨЗ 3.1(п)</b>	<p>Ашигтай ажилласан байх жилийн тоо: <i>заахгүй</i></p>																	
<b>ТОӨЗ 3.1(p)</b>	<p>Тендерт оролцогчийн санал болгосон бараа нь захиалагчаас шаардсан тухайн барааны тодорхойлолт /стандарт/-ын үзүүлэлт, нөхцөл тус бүрийг хангаж буйг харуулах техникийн тодорхойлолт, тайлбар нотлох баримтыг бэлтгэж тендерт ирүүлнэ.</p>																	
<b>ТОӨЗ 6.1</b>	<p>Тендер нээснээс хойш <b>5</b> хоногийн туршид хүчинтэй байна.</p>																	

<b>ТОӨЗ 7.1(а)</b>	Тендерийн эх хувиас гадна ирүүлэх хуулбар хувийн тоо: <b>цахим системээр ирүүлэх тохиолдолд хувь заахгүй</b>
	<b>Г. Тендер ирүүлэх</b>
<b>ТОӨЗ 7.1(б)</b>	<p>Тендер хүлээн авах захиалгчийн хаяг: Захиалгач тендерүүдийг хүлээн авах хаяг нь: Тендерийн материалыг Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">tender.gov.mn</a>) хаягаар өөрийн ААН-ийн хувийн нууцлалын кодыг ашиглан нэвтэрж цахим хэлбэр (PDF) файлаар илгээнэ. Цахим систем ашиглан илгээх нийт файлын хэмжээ 100 МБ, нэг файлын хэмжээ 15 МБ байна. Цахим тендер шалгаруулалт зохион байгуулах журмын дагуу тендерт оролцох хураамж 20,000 /тавин мянга/ төгрөгийг <a href="http://www.tender.gov.mn">http://www.tender.gov.mn</a>-ээр банкны меркантний системийг ашиглан төлнө.</p> <p><b>Төлбөр төлөх данс: 100170220010</b></p> <p>Тендер хүлээн авах этгээд: <b>Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ-ын Санхүүгийн албаны дарга Б.Цэндбаяр</b></p> <p>Байгууллагын хаяг: <b>Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГазар.</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ</b></p> <p>Аймаг, хот: <b>Хөвсгөл аймаг Арбулаг сум,</b></p> <p>Улс: <b>Монгол Улс</b></p>
<b>ТОӨЗ 7.1(в)</b>	<p>Тендер шалгаруулалтыг ялгаж, таних зорилгоор тендерийн гаднах болон доторх дугтуйд дараах нэр, ялгах дугаарыг гаргацтай тэмдэглэнэ: <b>Хөвсгөл аймгийн Арбулаг сумын Эрүүл мэндийн төвийн хоол хүнс нийлүүлэх гүйцэтгэгч сонгох, ХӨААБСЭМТ/20240202004</b></p> <p><b>Тендерт оролцогч нь тендерийн дугаар бүрийг дугаарлаж, гарын үсэг зурж баталгаажуулсан байна. Тендерийн эхний нүүрэнд тендерийн төвъёог хөтөлж оруулна.</b></p>
<b>ТОӨЗ 7.1 (г)</b>	<p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь:</p> <p>Тендер хүлээн авах эцсийн хугацаа нь Цахим худалдан авах ажиллагааны систем (<a href="http://www.tender.gov.mn">http://www.tender.gov.mn</a>)-ийн серверийн цагаар тооцогдох тул тендер хүлээн авах хугацаанаас хоцорсон тендерийн материал хүлээн авах боломжгүй. Тендер хүлээн авах эцсийн хугацаа дуусахаас өмнө илгээсэн тендерийн материалаа буцаан засварлах, нэмэлт өөрчлөлт оруулах эрхтэй.</p> <p>Огноо: <b>2024 оны 05 дүгээр сарын 24-ны өдөр</b></p> <p>Цаг: <b>12 цаг 00 минут</b></p>
	<b>Д. Тендерийг нээх, үнэлэх</b>
<b>ТОӨЗ 7.1(д)</b>	<p>Тендерийн нээлт хийх газрын хаяг нь дор өгөгдөв. Үүнд:</p> <p>Байшин, гудамжны нэр: <b>Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГ-ын санхүүгийн алба</b></p> <p>Давхар болон өрөөний дугаар: <b>Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЗДТГазар</b></p> <p>Аймаг, хот: <b>Хөвсгөл аймаг Арбулаг сум,</b></p> <p>Улс: <b>Монгол Улс</b></p> <p>Тендерийн нээлт хийх огноо, цаг нь:</p> <p>Огноо: <b>2024 оны 05 дүгээр сарын 24-ны өдөр</b></p>

	Цаг: <i>12 цаг 30 минут</i>
<b>ТӨӨЗ 7.1(е)</b>	<p><i>Арифметик алдааг тооцож тендерийн үнийг залруулах,</i></p> <p><i>Томоохон зөрүү тооцоогүй бага хэмжээний орхигдүүлсан зүйл буюу тоо хэмжээний зөрүүг тооцон мөнгөөр илэрхийлж, тендерийн үнэд залруулга хийх,</i></p> <p><i>-Тендерт оролцогчийн санал болгосон нэмэлт өөрчлөлт буюу үнийн хөнгөлөлтийг тусгах</i></p>
	<b>Е. Гэрээ байгуулах эрх олгох</b>
<b>ТӨӨЗ 8.1</b>	<p>Захиалагч барааны тоо хэмжээг бууруулж болох хамгийн их хувь: <i>0 хувь</i></p> <p>Нийлүүлэх барааны тоо хэмжээг өсгөж болох хамгийн их хувь: <i>0 хувь</i></p>
<b>ТӨӨЗ 8.1(а)</b>	<p>Гэрээ байгуулах эрх олгосон тухай болон тендерт шалгараагүй тухай мэдэгдлүүдийг <a href="http://www.tender.gov.mn">http://www.tender.gov.mn</a>, <a href="http://www.umch.khs.gov.mn">http://www.umch.khs.gov.mn</a> сайтад нийтэлж, оролцогчийн мэйл хаягаар илгээх тул тендерт оролцогч тендерт шалгарсан болон шалгараагүй мэдэгдлийг энд заасан мэдээллийн хэрэгслээс үзэж мэдээлэл авах үүрэгтэй. Мэдэгдлийн эх хувийг баталгаат шуудангаар илгээнэ.</p>

## Гурав. ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛОЛТ

### ҮННИЙ САНААЛЬН МАЯГТ

БАТЛАВ

ХӨВСГОЛ АЙМГИЙН АРБУЛАГ СҮМЫН ЭРҮҮЛ МЭНДИЙН ТӨВИЙН ДАРЛА

АГАнбаяр

- 1 Арбулаг үмт нь лор дурсан барааг үнийн санаалыаах баримт бийгийн тасуу 7 хоногийн доторчийн түүхээр санал болгож байна.
- 2 Нийтигүйл бараа нь техникийн тодорхойлолтын шарталдагтг бүрэн хангасны гучлах баримтай байх
- 3 Бид гэрээний срээний болон тусдай нөхцлийн хүзүүн зөвшөөрч бийна гэлийн угзар батланжиж байна

Баги:

№	Бараа бүтээгдэхүүний нэр	Техникийн тодорхойлолт	Хэмжих нэгж	Нэгж үнэ	Тоо ширхэг	Нийт үнэ	Нийлүүлэх хамгийн эхний хугацаа	Нийлүүлэх хамгийн эхний хугацаа
1	Байсаа		КГ	3,200.00	150.00	480,000.00	2024.04.01	2024.12.31
2	Заринь		Ш	9,200.00	20.00	184,000.00	2024.04.01	2024.12.31
3	Гаймон		Ш	3,600.00	50.00	180,000.00	2024.04.01	2024.12.31
4	Гурвалжин булаа		КГ	4,200.00	150.00	630,000.00	2024.04.01	2024.12.31
5	Гурил		КГ	2,350.00	40.00	940,000.00	2024.04.01	2024.12.31
6	Лавс иод		КГ	1,200.00	20.00	24,000.00	2024.04.01	2024.12.31
7	Далайн байцаа		Ш	4,850.00	100.00	485,000.00	2024.04.01	2024.12.31
8	Лууван		КГ	3,200.00	200.00	640,000.00	2024.04.01	2024.12.31
9	Майонез		Ш	11,500.00	30.00	345,000.00	2024.04.01	2024.12.31
10	Манжин		КГ	3,500.00	200.00	700,000.00	2024.04.01	2024.12.31
11	Огурцы		Ш	9,000.00	50.00	450,000.00	2024.04.01	2024.12.31
12	Сонино		КИ	3,500.00	50.00	175,000.00	2024.04.01	2024.12.31
13	Ургамалын тоос		КГ	12,000.00	30.00	360,000.00	2024.04.01	2024.12.31
14	Хобигч		Ш	850.00	100.00	85,000.00	2024.04.01	2024.12.31
15	Цай		Ш	7,600.00	50.00	380,000.00	2024.04.01	2024.12.31
16	Гурилан боов		Ш	5,500.00	60.00	330,000.00	2024.04.01	2024.12.31
17	Масло		Ш	12,000.00	150.00	1,800,000.00	2024.04.01	2024.12.31

18	Нэрэс анис шүүс							
19	Хөц булаа							
20	Цагваргыны шүүс							
21	Айнсны шүүс							
22	Гадах							
23	Пээр суу							
24	Калла							
25	Айм							
27	Сармис							
28	Ц.Пенчень							
29	Үхэрийн мах							
30	Акбар тай 25-тай							
31	Цаглан булаа							
32	Ш.Ползний замаг							
33	Элсэн чөлөр							
34	Улаан пошидор							
35	Лашала							
36	Өтгөрүүлсн жүүс							
38	Чанганнээ							
39	Зөвийн бал							
40	Петснүү кт							
41	Помидор							
42	Үзэм							
44	Ногон огорчий							
45	Аары							
46	Джаарийн наанч							
47	Лашала гоймон 3 кт							
48	Манур							
49	Сүү							
50	Төмс							
51	Өндөр.							
52	Бор дэвс							
53	Далайн замаг ууттай							

18	Нэрэс анис шүүс	Ш	15,300.00	300.00	4,590,000.00	2024.04.01	2024.12.31	
19	Хөц булаа	кт	4,200.00	200.00	840,000.00	2024.04.01	2024.12.31	
20	Цагваргыны шүүс	Ш	15,300.00	300.00	4,590,000.00	2024.04.01	2024.12.31	
21	Айнсны шүүс	Ш	15,300.00	300.00	4,590,000.00	2024.04.01	2024.12.31	
22	Гадах	Ш	3,500.00	150.00	555,000.00	2024.04.01	2024.12.31	
23	Пээр суу	Ш	5,550.00	100.00	555,000.00	2024.04.01	2024.12.31	
24	Калла	ш	3,800.00	20.00	76,000.00	2024.04.01	2024.12.31	
25	Айм	кт	5,500.00	50.00	275,000.00	2024.04.01	2024.12.31	
27	Сармис	кт	3,500.00	30.00	105,000.00	2024.04.01	2024.12.31	
28	Ц.Пенчень	кт	9,000.00	60.00	540,000.00	2024.04.01	2024.12.31	
29	Үхэрийн мах	кт	13,500.00	400.00	5,400,000.00	2024.04.01	2024.12.31	
30	Акбар тай 25-тай	Ш	7,500.00	20.00	150,000.00	2024.04.01	2024.12.31	
31	Цаглан булаа	кт	3,960.00	200.00	792,000.00	2024.04.01	2024.12.31	
32	Ш.Ползний замаг	кт	4,500.00	30.00	135,000.00	2024.04.01	2024.12.31	
33	Элсэн чөлөр	Ш	3,300.00	200.00	660,000.00	2024.04.01	2024.12.31	
34	Улаан пошидор	Ш	12,000.00	50.00	600,000.00	2024.04.01	2024.12.31	
35	Лашала	Ш	4,800.00	60.00	288,000.00	2024.04.01	2024.12.31	
36	Өтгөрүүлсн жүүс	Ш	15,500.00	157.00	2,435,500.00	2024.04.01	2024.12.31	
38	Чанганнээ	кт	24,000.00	50.00	1,200,000.00	2024.04.01	2024.12.31	
39	Зөвийн бал	Ш	9,900.00	10.00	99,000.00	2024.04.01	2024.12.31	
40	Петснүү кт	кт	9,500.00	50.00	475,000.00	2024.04.01	2024.12.31	
41	Помидор	кт	16,500.00	50.00	825,000.00	2024.04.01	2024.12.31	
42	Үзэм	кт	13,000.00	100.00	1,300,000.00	2024.04.01	2024.12.31	
44	Ногон огорчий	кт	12,000.00	30.00	360,000.00	2024.04.01	2024.12.31	
45	Аары	кт	6,000.00	100.00	600,000.00	2024.04.01	2024.12.31	
46	Джаарийн наанч	Ш	3,520.00	10.00	35,200.00	2024.04.01	2024.12.31	
47	Лашала гоймон 3 кт	Ш	18,040.00	20.00	360,800.00	2024.04.01	2024.12.31	
48	Манур	Ш	4,730.00	30.00	141,900.00	2024.04.01	2024.12.31	
49	Сүү	Ш	5,500.00	150.00	825,000.00	2024.04.01	2024.12.31	
50	Төмс	кт	2,200.00	200.00	440,000.00	2024.04.01	2024.12.31	
51	Өндөр.	Ш	660.00	520.00	343,200.00	2024.04.01	2024.12.31	
52	Бор дэвс	кт	1,300.00	20.00	26,000.00	2024.04.01	2024.12.31	
53	Далайн замаг ууттай	Ш	8,900.00	60.00	534,000.00	2024.04.01	2024.12.31	

54	Пунтууз		кг	2,400.00	20.00	48,000.00	2024.04.01	2024.12.31
55	Хөвсгол пай		ш	6,500.00	60.00	390,000.00	2024.04.01	2024.12.31
56	Шар будда		кг	4,800.00	150.00	720,000.00	2024.04.01	2024.12.31
57	Сгущётика славянка молоко		ш	15,500.00	30.00	465,000.00	2024.04.01	2024.12.31
58	Хонтын маx		кг	12,500.00	250.00	3,125,000.00	2024.04.01	2024.12.31
		Нийт				47,645,600.00		

Бараа нийлүүлэх хамгийн эхний хугацаа гарээ байгуулнаас хойш тухайн өдөр бүр

Бараа нийлүүлэх эцийн хугацаа 2024 оны 12-р сарын 31 хүртэл  
ТЕХНИКИЙН ТОДОРХОЙЛТ БОЛОВСРУУЛСАН .....  
.....Б.АЮУШЖАВ

## Дөрөв. ЖИШИГ МАЯГТ

### 1. ҮНИЙН САНАЛЫН МАЯГТ

[огноо]

(Захиалагч байгууллагын нэр)-ын дарга \_\_\_\_\_ танаа

- Бид, [тендерт оролцогчийн нэр] дор дурдсан барааг [санал болгож буй нийт үнийг тоогоор болон үсгээр] төгрөгөөр үнийн саналын авах баримт бичгийн дагуу [моо] хоногийн дотор нийлүүлэхээр санал болгож байна.
- Нийлүүлэх бараа нь техникийн тодорхойлолтын шаардлагыг бүрэн хангасныг гэрчлэх баримтыг хавсаргав.
- Бид гэрээний ерөнхий болон тусгай нөхцөлийг хүлээн зөвшөөрч байна гэдгийг үүгээр батламжилж байна.

Нэр төрөл	Тодорхойлолт	Барааны гарал үүслийн улс	Тоо ширхэг	Нэгж үнэ	Нийт дүн	НӨАТ болон бусад албан татвар	Бүгд дүн
1	2	3	4	5	6	7	8
Тендерийн нийт үнэ							

Баталгаат засварын хугацаа:

Санал болгож буй бусад нөхцөл:

Тендерт оролцогчийн нэр:

Эрх бүхий албан тушаалтны гарын үсэг, тамга:

Албан тушаал, нэр:

Хаяг:

## **2. НЭГДСЭН ХҮСНЭГТ: ӨМНӨ БОЛОН ОДОО ХЭРЭГЖИЖ БУЙ ГЭРЭЭ**

Тендерт оролцогч хэрэгжүүлсэн болон одоо гүйцэтгэж буй бүх гэрээний талаар мэдээлэл ирүүлнэ.

Уг мэдээлэл нь гэрээ хэрэгжүүлэх чадавхигүй болсон эсхүл ажил дуусгавар болсон гэрчилгээ буюу ажил хүлээлцсэн актаа хүлээн авч байгаа гэрээний хувьд хамаarahгүй.

Гэрээний нэр	Захиалагч, холбоо барих хаяг/утас/факс	Гэрээний үнийн дүн	Гэрээний эхлэх хугацаа	Гэрээний дуусах хугацаа
1.				
2.				
3.				
4.				
5.				
бусад.				

## Тав. ГЭРЭЭНИЙ ЕРӨНХИЙ НӨХЦӨЛ

<b>1. Шалгах болон турших</b>	1.1.	Техникийн тодорхойлолтыг хангаж буй эсэхийг баталгаажуулах зорилгоор захиалагч эсхүл түүний төлөөлөгч барааг шалгах, турших эрхтэй. Гэрээний тусгай нөхцөл (ГТН)-д, эсхүл техникийн тодорхойлолтод захиалагч ямар шалгалт, туршилтыг хэзээ, хаана хийхийг заана.
<b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт</b>	2.1.	Нийлүүлэгдэх бараа нь техникийн тодорхойлолтод нийцсэн байх ба холбогдох стандартыг заагаагүй бол тухайн барааны гарал үүслийн улсын зохих стандартад нийцсэн байна. Үүнд эдгээр стандартын хамгийн сүүлчийн найруулгыг ойлгоно. Нийлүүлэгч ГТН-д заасан бол түүний дагуу тээврийн болон бусад баримт бичгийг бэлтгэж бүрдүүлнэ.
<b>3. Оюуны өмчийн эрх</b>	3.1.	Бараа, эсхүл түүний эд ангийг өмчлөх, ашиглахад патент, худалдааны тэмдэг, зураг төслийн эрх гэх мэт оюуны өмчийн эрхийг захиалагч болон нийлүүлэгч зөрчсөн хэмээн гуравдагч этгээдийн нэхэмжилсэн гомдлыг нийлүүлэгч барагдуулж, холбогдон гарах зардлыг хариуцна.
<b>4. Бараа хүргэх, тээврийн баримт бичиг ирүүлэх</b>	4.1.	Гэрээнд хэрэглэсэн үнэ болон бусад худалдааны нэр томьёог Инкотермс (INCOTERMS) буюу Парис хот дахь Олон улсын худалдааны танхимаас боловсруулж гаргасан сүүлийн хувилбарт тодорхойлсон утгаар ойлгоно.
<b>5. Баталгаат засварын хугацаа</b>	5.1.	Үйлдвэрлэгчийн тухайн бараанд олгодог баталгаат засварын хугацаа <b>I</b> жил байна.
<b>6. Гэрээнд өөрчлөлт оруулах</b>	6.1.	Гэрээний дагуу нийлүүлэгдэх барааны нэр төрөл, үзүүлэлтийг өөрчлөхгүй.
<b>7. Төлбөр</b>	7.1.	Захиалагч төлбөрийг нэхэмжлэх хүлээн авснаас хойш <b>15</b> хоногийн дотор шуурхай хийнэ.
<b>8. Бараа нийлүүлэх хуваарь</b>	8.1.	Нийлүүлэгч барааг хүргэхдээ техникийн тодорхойлолтод заасан бараа нийлүүлэлтийн хуваарийг мөрдөнө.
<b>9. Алданги оногдуулах</b>	9.1.	Захиалагч нийлүүлэгчийн хугацаа хоцорч нийлүүлсэн бараа, гүйцэтгэсэн үйлчилгээний гэрээний үнийн ГТН-д заасан хувьтай тэнцэх алданги оногдуулж, гэрээний үнийг тэр хэмжээгээр бууруулна. Алдангийн нийт дүн ГТН-д заасан дээд хэмжээнээс хэтрэхгүй.
<b>10. Үүргээ биелүүлээгүй -гээс гэрээг цуцлах</b>	10.1.	Нийлүүлэгч гэрээний үүргээ биелүүлээгүй тохиолдолд захиалагч гэрээг цуцалж, захиалагчид учирсан аливаа хохирлыг нийлүүлэгч барагдуулна.
<b>11. Маргааныг шийдвэрлэх</b>	11.1.	Талууд гэрээний үүргийн биелэлттэй холбогдсон асуудлаар тохиролцоонд хүрч чадахгүй бол зохих тал шүүхэд нэхэмжлэл гаргана.

## Зургаа. ГЭРЭЭНИЙ ТУСГАЙ НӨХЦӨЛ

- |   |  |
|---|--|
| <b>1. Шалгах болон турших (ГЕН – 1)</b>                             | 1.1. Хөвсгөл аймгийн Онцгой байдлын газраас томилсон ажлын хэсэг шалгарсан оролцогчийн нийлүүлсэн бараа, ажил, үйлчилгээг туршиж, томилж хүлээн авна.  |
| <b>2. Барааны нийлүүлэлт ба баримт бичгийн бүрдүүлэлт (ГЕН – 2)</b> | 2.1. Нийлүүлэгчийн бүрдүүлэх тээврийн болон бусад баримт бичгүүд:<br><br>1) нийлүүлэгчийн барааны нэр, тоо ширхэг, нэгж болон нийт үнийг зассан нэхэмжлэхийн хувь;<br>2) Санхүүжилт хүссэн албан тоот;<br>3) Хүнсний бүтээгдэхүүн нийлүүлсэн гүйцэтгэлийг төслийн менежерээр баталгаажуулна;<br>4) Нийлүүлж байгаа барааны шинжилгээний дүгнэлт ;<br>5) Хүлээн авсан ажлын хэсгийн акт<br><br>Энд жагсаасан баримт бичгийг бараа хүрэлцэн ирэхээс өмнө захиалагчид өгсөн байна. Баримт бичгийг энэ хугацаанд захиалагчид өгч чадаагүйгээс гарах зардлыг нийлүүлэгч хариуцна. |
| <b>3. Баталгаат засвар (ГЕН-5)</b>                                  | 5.1. Баталгаат засварын тусгай шаардлагагүй.   |
| <b>4. Төлбөр (ГЕН – 7)</b>  | 7.1. Гэрээний ерөнхий нөхцөлийн 7 дугаар зүйлийг дараах байдлаар дэлгэрүүлнэ. Үүнд:<br><br>Гүйцэтгэлээр барааг хүлээн авсан акт болон гэрээний ерөнхий нөхцөлийн 2 дугаар зүйлд заасан баримт бичгийг үндэслэн төлнө.  |
| <b>5. Алданги оногдуулах (ГЕН - 9)<sup>2</sup></b>                  | 9.1. Алданги оногдуулах хувь: Гэрээний үнийн дүнгийн <b>0,5 хувь байна.</b><br><br>Алдангийн нийт дүн: Гэрээний үнийн дүнгийн 10 хувиас хэтрэхгүй.   |

<sup>2</sup> Ихэнх тохиолдолд, нэг долоо хоногт оногдуулах алданги гэрээний үнийн 0.5 хувиас, алдангийн нийт дүн гэрээний үнийн дүнгийн 10 хувиас тус тус хэтрэхгүй.

# Долоо. ГЭРЭЭНИЙ МАЯГТ<sup>3</sup>

## БАТЛАВ.

### ЗАХИАЛАГЧ

АРБУЛАГ СУМЫН ЭМТӨВИЙН ДАРГА  
Б.БАЯРМОНХ

### НИЙЛҮҮЛЭГЧ

"ХХК-ИЙ ЗАХИРАЛ  
Н.БББББББББ

*Хөвсгөл аймгийн Арбулаг сумын ЭМТөвийн хоол хүнс нийлүүлэх гэрээ.*

Дугаар № ХӨ-2018/8.5.3

..... хот/аймаг

Нэг талаас **[захиалагчийн нэр]** (цаашид “захиалагч” гэх), нөгөө талаас **[нийлүүлэгчийн нэр]** (цаашид “нийлүүлэгч” гэх) дараах зүйлийг харилцан тохиролцож \_\_\_\_\_ оны \_\_\_\_ сарын \_\_\_\_ -ны өдөр энэхүү ГЭРЭЭГ (цаашид “гэрээ” гэх) байгуулав.

1. Монгол Улсын Иргэний болон бусад хууль тогтоомжийн дагуу бараа, бүтээгдэхүүн нийлүүлэхтэй холбогдон захиалагч, нийлүүлэгчийн хооронд үүсэх харилцааг зохицуулах, харилцан хүлээх үүрэг, хариуцлагыг тогтооход энэхүү гэрээний ач холбогдол оршино.
2. Захиалагч нь **[гэрээний нэр, дугаар]-г** (цаашид “бараа” гэх) **[гэрээний үнийг тоогоор болон үсгээр]** (цаашид “гэрээний үнэ” гэх) нийлүүлэхээр ирүүлсэн нийлүүлэгчийн тендерийг үүгээр хүлээн зөвшөөрөв. Гэрээний үнэ нь санхүүжилтийн нийт гүйцэтгэл болно.
3. Захиалагч нь барааны нийлүүлэлтийг \_\_\_\_\_ төгрөгийн улсын төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр, \_\_\_\_\_ төгрөгийн өөрийн хөрөнгөөр санхүүжүүлнэ.
4. Нийлүүлэгч нь \_\_\_\_\_ нэр төрлийн барааг \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-наас \_\_\_\_\_ оны \_\_\_\_ дугаар сарын \_\_\_\_-ны өдрийн дотор нийлүүлж хүлээлгэж өгнө.
5. Дор дурдсан баримт бичиг нь гэрээний салшгүй хэсэг болно (цаашид “гэрээний баримт бичиг” гэх). Үүнд:

Гэрээ байгуулах эрх олгох тухай мэдэгдэл;  
Бусад шаардлагатай баримт бичиг<sup>4</sup>;  
Үнийн санал;  
Гэрээний тусгай нөхцөл;  
Гэрээний ерөнхий нөхцөл;  
Техникийн тодорхойлолт болон бараа нийлүүлэлтийн хуваарь;  
Санхүүжилтийн хуваарь.

<sup>3</sup> Гэрээ байгуулах үед үүний хасна.

<sup>4</sup> Хоёр тал харилцан тохиролцож гэрээний нөхцөлд оруулсан зайлшгүй шаардлагатай нэмэлт, өөрчлөлтүүд.

Гэрээ нь энд дурдсан барааны нийлүүлэлтийн талаарх талуудын хоорондын эцсийн тохиролцоо болох ба урьд өмнө үйлдсэн бүх хэлцлийг орлоно. Хэрэв гэрээний баримт бичгүүд хоорондоо зөрчилдвэл дээр дурдсан дарааллын дагуу ач холбогдол өгч шийдвэрлэнэ.

6. Нийлүүлэгч нь энэ гэрээний дагуу захиалагчийн төлөх төлбөрийг үндэслэн энэхүү гэрээний бүх нөхцөл, болзолд нийцүүлэн энд заасан барааг нийлүүлж, гэмтэл согог арилгах үүрэг хүлээнэ.
7. Захиалагч нь гэрээний дагуу нийлүүлэгчийн нийлүүлэх бараа болон гэмтэл согог арилгах үйлчилгээг үндэслэн гэрээний үнэ, эсхүл тухайн үед гэрээний заалтын дагуу төлөх бусад дунг гэрээнд заасан хэлбэрээр нийлүүлэгчид төлөх үүрэг, хүлээнэ.
8. Гэрээнд холбогдох асуудлаар талууд албан бичгээр буюу шуудан, телекс, цахилгаан болон факсаар харилцана.

**ЗАХИАЛАГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]

**НИЙЛҮҮЛЭГЧИЙГ ТӨЛӨӨЛЖ:**

[Албан тушаал, нэр]  
[Гарын үсэг]\_\_\_\_\_

ТАМГА

[Захиалагчийн хаяг]  
[Утас/факсын дугаар]  
[Харилцагч банкны нэр, дансны дугаар]